



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар Д/149

Хэрлэн сум

Дэлхийн мөрөөдлийн сургууль НҮТББ дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн мөрөөдлийн сургууль НҮТББ-аас аймгийн ахлах ангийн сурагчдад зориулан Ерөнхийлөгчийн илгээлт 2100 тэтгэлэг, ЭЕШ-д үр дүнтэй бэлдэх, хэлний оноо авах тухай, гадаадын их дээд сургуулийн тэтгэлгийн талаарх мэдээлэл өгөх зардалд зориулж 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ